



СОЁМБО

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№24 /468/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.02.02

Цаг үе, үйл явдал

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ 2022 ОНЫ ТАЙЛАНГИЙН ХУРЛАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Өнөөдөр БХЯ тайлангийн хурлаа хийж 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ, амжилт бүтээл, алдаа оноогоо дүгнэсний зэрэгцээ энэ онд анхаарч ажиллах шаардлагатай зарим асуудлуудыг хэлэлцлээ.

Батлан хамгаалах яамны 2022 оны үйл ажиллагааны тайлан болон түүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг БХЯ-ны ТЗУГ-ын даргын үүргийг түр орон гүйцэтгэгч хурандаа Р.Энхболд, ХШУДАГ-ын даргын үүргийг түр орон гүйцэтгэгч хурандаа Н.Пүрэвдорж нар нийт бие бүрэлдэхүүнд танилцууллаа. Батлан хамгаалах яам нь 2022 онд үйл ажиллагааны зорилгоо "Яамны үйл ажиллагааны бодлогын удирдамж, эрх

зүй, зохион байгуулалтын удирдлага, зохицуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээний нэгдсэн байдлыг хангаж, батлан хамгаалах тогтолцоо, Зэвсэгт хүчний хөгжлийн дунд хугацааны зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлнэ" хэмээн тодорхойлж, уг зорилгын хүрээнд нийт 173 ажил, арга хэмжээг төлөвлөн 92,6 хувийн биелэлттэйгээр гүйцэтгэж өмнөө тавьсан зорилго зорилтуудаа бүрэн хангажээ.

2022 онд Батлан хамгаалах яам төрийн батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх, мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх зорилгыг хангахад ахиц гаргасан, гадаад харилцаа, хамтын



ажиллагааг идэвхжүүлсэн, томоохон төсөл, арга хэмжээгээ урагшлуулсан, улс орныхоо стратегийн бүтээн байгуулалтын ажилд манлайлан оролцсон, алба хаагчдынхаа ажиллах, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулсан, цалин хөлсийг нэмэгдүүлэх бодлого, шийдвэр гаргасан, хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдмэл байдлыг хангасан зэрэг ололттой олон ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Тухайлбал, "Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-ийг УИХ-аар батлуулан, Цэргийн тагнуулын газрыг Зэвсэгт хүчний Жанжин штабын бүтцэд шилжүүлсэн.

Өнгөрсөн оны 03 дугаар сард "Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын даргад өргөн барьсан.

"Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай", "Цэргийн алба хаагчийн эрх

зүйн байдлын тухай" хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг холбогдох яамд, мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж байна.

Үүнээс гадна "Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд"-ийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 180 дугаар зарлигаар шинэчлэн батлуулсан.

"Орон нутгийн хамгаалалтын тухай хууль"-ийн дагуу 2022 онд анх удаа "Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн дадлага, сургалт"-ыг Өвөрхангай аймгийн Цэргийн штабтай хамтран амжилттай зохион байгуулж явуулсан. Энэ онд тус "Хээрийн дадлага" сургалтыг хэд хэдэн аймагт зохион байгуулна.

"Засгийн газрын хуралдаанаар цэргийн алба хаагчийн албан тушаалын ангилал, цэргийн цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэн тогтоосон. Үүний үр дүнд алба хаагчдын албандаа хандах хандлага, итгэл үнэмшил нэмэгдэж, мэдлэг чадвараа хөгжүүлэх, албан тушаал эзэмшсэн мэргэжилдээ тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдсэн.

-Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр 2022 онд Бүгд Найрамдах Филиппин Улстай "Батлан хамгаалах яамд хоорондын цэргийн салбарт хамтран ажиллах санамж бичиг", Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улстай "Батлан хамгаалах яамд хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг тус тус анхлан байгуулж, Эмэгтэй энхийг сахиулагчдын олон улсын бага хурлыг эх орондоо амжилттай зохион байгуулсан. Мөн гадаад улс орнуудтай хамтарсан "Хааны эрэлд-2022", "Сэлэнгэ-2022", "Восток-2022", "Бланс Межик-2022", "Бүс нутгийн хамтын ажиллагааны олон улсын команд штабын сургууль", "Кобра голд" команд штабын сургууль, "Зам" инженерийн сургууль зэрэг хээрийн сургууль, хамтарсан дадлагуудыг амжилттай зохион байгууллаа.

-Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийн бэлэн байдлыг дээшлүүлэх ажлын хүрээнд 36 нэгж автотехник, тусгай тоноглолтой техник, хэрэгслийг Зэвсэгт хүчний 8 анги байгууллагад, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 29 нэгж автотехник, тусгай тоноглолтой автомашиныг шилжүүлэн хүлээн авч, Зэвсэгт хүчний 7 анги байгууллагад тус тус хүлээлгэн өгсөн.

-Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ҮБХИС-ийн ном, мэдээллийн төвийн барилга, Зэвсэгт хүчний хөгжлийн сан болон Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажлаас олсон орлогоор Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн штаб, Агаарын цэргийн командлалын харьяа 3 тусгай салбарын алба хаагчдын 8 айлын орон сууц, Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн онгоцны ангарын барилга, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд жишиг 200 цэргийн алба хаагчийн байрыг шинээр барьж ашиглалтад оруулснаас гадна Зэвсэгт хүчний зарим ангидын цэргийн байр, гал тогоо, агуулахуудын их болон урсгал засварын бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

ҮБХИС-ийн ЦНДС-ийн офицер бэлтгэх сургалтын тогтолцоонд томоохон өөрчлөлт оруулсан, "Алдар" спорт хорооны баг, тамирчид Монголын Бүх ард түмний спортын XV их наадамд тэргүүлсэн, улсын хэмжээнд цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг амжилттай зохион байгуулсан, Цэргийн төв эмнэлэг тоног, төхөөрөмж, хүчин чадлын хувьд улам сайжирсан.

Мөн Авлигатай тэмцэх

газраас явуулдаг шударга байдлын үнэлгээгээр 2021 онд БХЯ нь 16 яамдаас 69,5 оноогоор 14 дүгээрт эрэмбэлэгдсэн бол 2022 онд тэргүүлсэн амжилтыг үзүүлсэн зэрэг онцлох ажил арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна.

Үүний дараагаар Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр БХЯ-ны 2022 оны үйл ажиллагааны тайлантай холбогдуулан хэлсэн үгэндээ өнгөрсөн онд Батлан хамгаалах салбар нэлээдгүй ажил, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлснийг онцлоод энэ ондоо дотоод нөөц, бололцоо бүхий л зүйлээ дайчлан ажиллаж илүү их зүйлийг хамтдаа хийж бүтээн гэдэгт найдаж буйгаа илэрхийлж дараах үүрэг чиглэлийг бие бүрэлдэхүүнд өгсөн юм.

Үүнд, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, -2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг бүрэн гүйцэт биелүүлэхэд анхаарч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах,

-Батлан хамгаалах салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд боловсруулсан хуулиудыг Монгол Улсын Засгийн газар, УИХ-аар эцэслэн батлуулах, -Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн засварлах талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулан Монгол Улсын Засгийн газар, УИХ-аар батлуулах,

-Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх, түүнд шаардлагатай туршилт, судалгаа, шинжилгээний ажлыг нэмэгдүүлэх, тасралтгүй зохион байгуулах, -Сумны үйлдвэрийг барьж байгуулах ажлыг эрчимжүүлж энэ ондоо багтаан ашиглалтад оруулах,

-Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газраар батлуулах, -Батлан хамгаалах бодлого, зорилтыг ард иргэдэд сурталчлах, таниулах, иргэн, цэргийн харилцааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх соён гэгээрлийн ажлыг эрчимжүүлэх,

-БХЯ-ны харьяа ТӨАТҮГ-уудын ашиг, орлогыг нэмэгдүүлэх, үргүй зардлыг танах, -Цэргийн алба хаагчдын мэргэжил болон бие бялдрын бэлтгэлтийг дээшлүүлэх, аливаа албан тушаалд томилогдохдоо төрийн албаны мерит зарчмаар дэвшдэг байх зэрэгт онцгой анхаарч ажиллахыг бие бүрэлдэхүүнд үүрэг болголоо.

Ө.НАСАНТОГТОХ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-9	-27


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,494	3,498
EUR	3,815	3,825
CNY	518	519
RUB	48	48.80
JPY	27	27.25
KRW	2.84	2.86

ЗУРХАЙ



2023.02.02 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 12

ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал: Өвчин эмгэг ирнэ Наран ургах, шингэх: 08.19-17.53 Барилдлага: Үл зохилдох Шүтэн барилдлага: Өтлөх үхэхүй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. / муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, эд хураах, номын өглөг өгөх, угаах, гадагш эд өгөхөд сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нь бол элчтэй учрах, хөл тагнай татвал өөрийн гэрт үзэсгэлэн болох, бие татвал бурханыг дурьдахуй болой.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 675,491,566

Эдгэрсэн

Нийт: 647,849,700

Нас барсан

Нийт: 6,764,989



ЖАНЖИН Д.СҮХБААТАРЫН ХӨШӨӨНД ЦЭЦЭГ ӨРГӨЖ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Монгол ардын намыг үүсгэн байгуулагчдын нэг, төр нийгмийн нэрт зүтгэлтэн, Ардын засгийн газрын Цэргийн явдлын яамны тэргүүн сайд, бүх цэргийн жанжин Д.Сүхбаатарын мэндэлсний 130 жилийн ой өнөөдөр тохиож байна. Энэхүү үйл явдалтай холбогдуулан Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб, жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит нийслэлийн ерөнхий боловсролын 2 дугаар сургууль хамтран тус сургуулийн хашаан дахь жанжин Д.Сүхбаатарын хөшөөнд хүндэтгэл үзүүлээ.

Үүний дараагаар хүрэлцэн ирсэн зочдод "Д.Сүхбаатар-130 жил" түүхэн баримтат киног толилуулсан бөгөөд сурагчдын төлөөлөл хэсэгчилсэн урлагийн

тоглолтыг үзүүлсэн юм. Үргэлжлүүлэн тус сургуулийг төгсөөд хугацаат цэргийн албанд татагдаж 032 дугаар ангийн байлдагч нарын эгнээнд орсон Ч.Энхбилэг, О.Энхтулга нар өөрийн алба хааж буй цэргийн ангийнхаа талаар сургуулийн бие бүрэлдэхүүнд танилцуулж, эр цэргийн албаны талаарх өөрийн сэтгэгдлээ хуваалцсан юм.

Энэ үеэр тус сургуулийн захирал Л.Цэнгэлмаа "Манай сургууль 1931 онд анх байгуулагдсан түүхтэй. Жил бүр Жанжин Д.Сүхбаатарын мэндэлсэн өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Энэ удаагийн арга хэмжээний онцлог нь сургуулийн багш, удирдлагын зүгээс эл түүхт өдрийг угтан нийт сурагчдын дунд

"Жанжны түүхэн дэх гавьяа" сэдэвт эсээ бичлэгийн болон гар зургийн уралдааныг амжилттай зохион байгуулж шилдгүүдээ тодруулсан. Бидний үйл ажиллагааг үргэлж дэмжиж ажилладаг Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб болон бусад боловсролын байгууллагууддаа энэ түүхэн ойн баярын мэндийг хүргэхийн сацуу баярлаж талархаж байгаагаа илэрхийлье" гэлээ.

Дэслэгч Т.ИДЭР



ЦЭРЭГЖЛИЙН ГИМНАСТИКИЙН ТЭМЦЭЭН ЭХЭЛЛЭЭ



Бүх цэргийн нэрт жанжин Д.Сүхбаатарын мэндэлсний 130 жилийн ой өнөөдөр тохиож байна. Түүхэн энэ өдөр жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Зэвсэгт хүчний цэрэгжлийн гимнастикийн 2023 оны аварга шалгаруулах тэмцээний нээлт энэ цаг үед ҮБХИС-д зохион байгуулагдаж байна. Тэмцээний нээлтэд Батлан хамгаалахын Ерөнхийханан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, жанжин Д.Сүхбаатарын зээ охин Д.Сүхжаргалмаа болон жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит байгууллагуудын удирдлага, тамирчин дайчид оролцож байна.

Цэрэгжлийн спорт нь цэргийн алба хаагчдын тэсвэр

хатуужлыг нэмэгдүүлж, хүч тэнхээ суулгадаг өндөр үр дүн, ач холбогдолтой бөгөөд Монгол Улсад орчин цагийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх үйл хэргийн анхны шанг татсан хүмүүс бол цэргийнхэн билээ.

Жанжин Д.Сүхбаатар 1921 онд 30 дугаар тушаалаар цэргийн анги нэгтгэлүүдийн дэргэд биеийн тамирын талбай бэлтгэх, гимнастик, дүүжин, савлуур, модон моринд харайлт, сонс эргэх зэрэг биеийн тамирын төрлүүдийг дэлгэрүүлэх, гимнастикийн дасгалыг цэргүүдээр тогтмол хийлгэж байх журам тогтоож байсан юм.

Дэд хурандаа С.ЭНХТАЙВАН



ХУРАНДАА Ц.БУЯНДЭЛГЭР: ХУГАЦААТ АЛБАНЫ ДАЙЧИД НЭГНЭЭСЭЭ СУРАЛЦАЖ, НӨХӨРЛӨСӨН ЧУХАЛ АРГА ХЭМЖЭЭ БОЛЛОО



Зэвсэгт хүчин 2023 оныг "Залуу офицеруудын манлайллын жил" болгосонтой холбогдуулан Монгол Улсын баатар, хурандаа генерал Б.Цогийн нэрэмжит Зэвсэгт хүчний 120 дугаар ангийнхны санаачилгаар Зэвсэгт хүчний 119, 120, 326 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн сургалт бэлтгэл, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг нэмэгдүүлэх зорилготой "Тактик жагсаалын нэгдсэн хичээл"-ийг гурван үе шаттайгаар амжилттай зохион байгууллаа.

Хугацаат цэргийн алба хаагчдын

цэргийн хэргийн мэдлэг, ур чадвараа сорин өрсөлдөж, бусад нөхдийнхөө цэргийн орчин нөхцөлтэй танилцсан энэхүү арга хэмжээ 1 дүгээр сарын 27-31-ний өдрүүдэд явагдсан юм. Эхний үе шат нь 1 дүгээр сарын 27-ны өдөр Зэвсэгт хүчний 119 дүгээр ангид явагдаж, гурван ангийн дайчид буудлагын дасгал боловсруулж, гранат шидэлтээр цэц мэргэнээ сорьсон бол хоёр дахь шат нь 1 дүгээр сарын 30-ны өдөр Зэвсэгт хүчний 326 дугаар ангид үргэлжилж, "Тусгай бэлтгэлийн нормативын буухиа" болон "АХА" танин мэдэхүйн асуултаар өрсөлдөв.

Харин төгсгөлийн гуравдугаар шат нь нэгдсэн арга хэмжээг санаачлагч Зэвсэгт хүчний 120 дугаар ангид 1 дүгээр сарын 31-ний өдөр явагдаж, Цэргийн тангараг давтаж, волейбол, ширээний теннисээр аваргаа тодруулан, дүн гаргах, шагнал гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулсан юм.

Гурван ангийн дайчид оролцсон "Тактик жагсаалын нэгдсэн хичээл"-ийн хаалтын ёслолын ажиллагаанд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга хурандаа Ц.Буяндэлгэр, Нийслэлийн Цэргийн штабын дарга хурандаа Г.Ялалт, Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Л.Цэрэгбаяр, Төв аймгийн Алтанбулаг Сумын засаг дарга Б.Батсуурь тэргүүтэй албаны хүмүүс оролцлоо.

Энэ үеэр хурандаа Ц.Буяндэлгэр хэлсэн үгэндээ "Салаа, салбарын захирагч нарын удирдах ур чадвар, хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн мэргэжлийн болон хувь

хүний манлайллыг хөгжүүлэхэд үлгэрлэл үзүүлсэн чухал сургалт боллоо. Цэргийн хэргийн мэдлэгээс гадна бусад нөхдийнхөө алба хааж буй орчин нөхцөлтэй танилцаж, алба хааж буй ангийнх нь алдар түүхээр "аялж", нөхөрлөж, нэгнээсээ суралцсан сайхан цаг мөч байсан гэдэгт нь эргэлзэхгүй байна. Хүн төвтэй байж, нэг бүрийн бэлтгэл сургалтыг шалгасан энэ төрлийн нэгдсэн хичээлийг цаашид уламжлал болгон зохион байгуулна. Хугацаат цэргийн алба хаагчдаа сургаж бэлтгэхэд онцгой анхаарч байгаа салаа, салбарын захирагч нартаа талархаж байна" гэсэн юм.

Мөн энэхүү нэгдсэн арга хэмжээг санаачлагч Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн захирагч хурандаа Э.Мөнх-Оргил "Хугацаат цэргийн алба хаагчид маань цэргийн эрдмийг чадамгай эзэмшсэн, эрдэм мэдлэг, эр зориг, тэсвэр хатуужил, эх оронч үзэл, хандлагаар төлөвшсөн эр хүн болж халагдах нь бидний гол зорилго билээ. Энэ

удаагийн тактик жагсаалын нэгдсэн хичээлийн зорилго нь үүнд оршино. Энэхүү ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, Нийслэл болон дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, хамтран оролцсон Зэвсэгт хүчний 119, 326 дугаар ангийн удирдлага, хамт олонд талархсанаа илэрхийлье" гэв.

Ийнхүү "Тактик жагсаалын нэгдсэн хичээл"-ийн тусгай хөтөлбөрөөр явагдсан буудлага, гранат болон бусад цогцолбор тэмцээнд нийт дүнгээр Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчид тэргүүлсэн юм. Шагналыг Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга хурандаа Ц.Буяндэлгэр, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Г.Ялалт, Нийслэлийн Баянгол дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Л.Цэрэгбаяр нар гардууллаа.

Хошууч Ө.НАРАНТУЯА

